

\_\_\_ (өдөр) \_\_\_ (сар) 20 \_\_\_

\_\_\_ (day) \_\_\_ (month) 20 \_\_\_

Энэхүү “Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, 14210, Энхтайваны өргөн чөлөө 19 хаягт орших Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх, нөгөө талаас иргэн \_\_\_\_\_ (регистрийн дугаар \_\_\_\_\_) (цаашид “Харилцагч” хамтад нь “Талууд” гэх), нар дараах нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ гэрээгээр Банк харилцагчийн хүсэлтийн дагуу харилцагчийг банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнд бүртгэх, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, Харилцагч төлбөр тооцооны үйлчилгээг авах, бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл Банканд төлөх, данс нээх, хаах, зээл авах болон зайнаас банкны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор талуудын эрх, үүрэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

### ХОЁР. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

#### ҮНДСЭН НӨХЦӨЛ

2.1. Харилцагч Банктай дараах банкны мэдээлэл, үйлчилгээ авах сувгуудаар дамжуулан харилцана. Үүнд:

2.1.1. Банкны салбар, тооцооны төвүүд;

2.1.2. Банкны лавлах төвийн утасны дугаар (19001977, 70161988);

2.1.3. Банкны лавлах төвийн цахим шуудангийн хаяг (info@tdbm.mn);

2.1.4. Банкны www.tdbm.mn цахим хуудас;

2.1.5. Банкны чат программ болон олон нийтийн сүлжээний чат;

2.1.6. Харилцагчтай зайнаас холбогдох боломж бүхий банкны бусад хэрэгслүүд.

2.2. Харилцагчийн хүсэлтийн дагуу түүний Банканд өгсөн үнэн, зөв мэдээллийг үндэслэн Банк харилцагчид дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

2.2.1. Харилцах данс (цаашид “Данс” гэх) нээж, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх;

2.2.2. Төлбөрийн дебит карт (цаашид “Карт” гэх) олгож, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх;

2.2.3. Ти Ди Би Онлайн үйлчилгээ (цаашид “Ти Ди Би Онлайн” гэх)-нд бүртгэж, зайнаас банкны үйлчилгээ үзүүлэх;

2.2.4. Мост Мони үйлчилгээ (цаашид “Мост Мони” гэх)-нд бүртгэж, зайнаас банкны үйлчилгээ үзүүлэх;

2.2.5. Тогтмол шилжүүлгийн үйлчилгээ (цаашид “Тогтмол шилжүүлэг” гэх)-нд бүртгэж, харилцагчийн заасан хугацаа, тогтмол дүнгээр төлбөр тооцоог гүйцэтгэх, бүртгэлийг сунгах, цуцлах;

2.2.6. И-биллингийн үйлчилгээ (цаашид “И-биллинг” гэх)-нд бүртгэж, нэхэмжлэгч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхэд үндэслэн харилцагчийн данснаас төлбөрийг шилжүүлэх;

2.2.7. Мессеж банкны үйлчилгээ (цаашид “Мессеж банк” гэх)-нд бүртгэж, харилцагчийн мэдээлэл авахаар сонгосон и-мэйл хаяг эхсүл гар утасны дугаараар мэдэгдэл илгээх;

2.2.8. Лавлах төвийн зайн сувгуудаар үйлчлүүлж мэдээлэл, лавлагаа авах, зайнаас зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн, үйлчилгээнд бүртгүүлэх;

2.2.9. Банкнаас зайнаас олгохоор санал болгож буй зээлийн үйлчилгээг авахаар гаргасан харилцагчийн хүсэлтийг хүлээн авах, хүсэлтийг судалж, холбогдох шаардлага хангасан тохиолдолд харилцагчийн хүсэлтийн дагуу зээл олгох.

2.3. Банк харилцагчид бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхдээ дараах хэлбэрээр харилцагчийг баталгаажуулна. Үүнд:

This ‘Customer Service Agreement’ has been entered by and between Branch / Clearing and Settlement Centre \_\_\_\_\_ of the **Trade and Development Bank** with its principal address at Peace Avenue 19, Subdistrict 1, Sukhbaatar District, Ulaanbaatar 14210, Mongolia (*hereinafter referred to as ‘the bank’*) on the one hand, and \_\_\_\_\_, a private individual, (*Registration No. \_\_\_\_\_*) (*hereinafter referred to as ‘the customer’*) on the other (*hereinafter collectively referred to as ‘the parties’*) upon mutual consent of the following terms.

### One. General provisions

1.1 The purpose of this agreement is to regulate matters arising in connection with the rights and obligations of the parties, in relation to the bank registering the customer for banking products and services at the latter’s request, and providing payment and settlement services, the customer receiving payment and settlement services, paying fees for the banking products and services, opening or closing accounts and taking out loans, as well as the provision of remote banking services.

### Two. Principal terms applicable to the provision of products and services

2.1. The customer will communicate with the bank through the following channels dedicated for providing the bank’s information and services:

2.1.1. branches and clearing and settlement centres of the bank;

2.1.2. phone number of the bank’s customer information centre (*19001977 and 70161988*);

2.1.3. electronic mail of the bank’s customer information centre (*info@tdbm.mn*);

2.1.4. website of the bank (*www.tdbm.mn*);

2.1.5. the bank’s online chat platform and social media direct message;

2.1.6. other facilities of the bank that enable long-distance contact with customers.

2.2. The bank will provide the following products and services to the customer at the latter’s request, based on accurate information provided by the customer to the bank:

2.2.1. open a current account (*hereinafter referred to as ‘the account’*) and provide payment and settlement services;

2.2.2. issue a debit card (*hereinafter referred to as ‘the card’*) and provide payment and settlement services;

2.2.3. register for TDB Online services (*hereinafter referred to as ‘TDB Online’*) and provide remote banking services;

2.2.4. register for Most Money services (*hereinafter referred to as ‘Most Money’*) and provide remote banking services;

2.2.5. register for standing order services (*hereinafter referred to as ‘standing order’*), execute payments in a fixed amount and within a time frame specified by the customer, and extend or cancel the setting;

2.2.6. register for e-billing services (*hereinafter referred to as ‘e-billing’*) and transfer funds from the customer’s account based on invoices sent by work or service providers;

2.2.7. register for message banking services (*hereinafter referred to as ‘message banking’*) and send notifications to an e-mail address or mobile phone chosen by the customer for receiving information;

2.2.8. receive information, references and referrals via remote service

2.3.1. Банкны салбар, тооцооны төвөөр үйлчилгээ үзүүлэх бол харилцагчийг баталгаажуулах үндсэн мэдээлэл нь харилцагчийн зураг, баталгаат гарын үсэг, иргэний хүчин төгөлдөр баримт бичиг байна.

2.3.2. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг зайнаас авах тохиолдолд энэхүү гэрээний 2.2-д заасан бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглагдах нэвтрэх нэр, нууц үг, пин код мөн Банканд бүртгэлтэй харилцагчийн цахим шуудангийн хаяг, утасны дугаар, нууц асуулт, хариулт болон бусад баталгаажуулалтын хэрэгслүүд нь тухайн харилцагчийн баталгаат гарын үсэг (тамга, тэмдгийн дардас)-ын адил хүчин төгөлдөр болохыг Талууд үүгээр зөвшөөрч, харилцан тохиролцов.

2.4. Харилцагч эзэл авах болон данс нээлгэх хүсэлтийг зайнаас илгээсэн тохиолдолд энэхүү гэрээний 2.3.2-д заасан баталгаажуулах хэлбэрээр тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний гэрээг цахимаар баталгаажуулж болох ба ийнхүү баталгаажуулсан нь уг гэрээг бичгээр байгуулсантай нэгэн адил хүчин төгөлдөр байхаар Талууд харилцан тохиролцов.

2.5. Нийтэд зарласан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл (цаашид "БҮЕН" гэх)-д тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг, Хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл (цаашид "ХШЕН" гэх)-д банкны бүтээгдэхүүн үйлчилгээний хүү, шимтгэлийг тус тус хамруулан ойлгоно.

2.6. Харилцагч энэхүү гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаар энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох ба тухайн үед мөрдөгдөж байгаа БҮЕН, ХШЕН-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрсөн болно. Цаашид БҮЕН, ХШЕН-д орох нэмэлт, өөрчлөлтүүдийг Харилцагч Банкны [www.tdbm.mn](http://www.tdbm.mn) цахим хуудсаар орж танилцах, Банк харилцагчийн Банканд бүртгүүлсэн цахим шуудангийн хаягаар дамжуулан мэдээлэхээр тохиролцов.

2.7. Банк цахим хуудсаараа дамжуулан БҮЕН, ХШЕН-д нэмэлт, өөрчлөлт орох талаар нийтэд мэдээлснээр харилцагчаас тухайн нэмэлт, өөрчлөлтийн талаар энэхүү гэрээнд заасан хугацаанд санал, хүсэлт ирүүлээгүй бол БҮЕН, ХШЕН-д орсон нэмэлт, өөрчлөлтийг Талууд хүлээн зөвшөөрсөн гэж үзэхээр харилцан тохиролцов.

2.8. Харилцагч нь энэхүү гэрээг Банктай байгуулснаар Банканд Зээлийн мэдээллийн сан болон Цахим мэдээллийн сангаас өөрийн мэдээллийг харах эрхийг зөвшөөрсөн болно.

2.9. Энэхүү гэрээний дагуу ямар төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авч байгаа болох нь Харилцагчийн уг гэрээг байгуулах үед гаргасан болон цаашид гаргах хүсэлтээр тодорхойлогдоно. Энэхүү хүсэлт нь Гэрээний хавсралт болно.

2.10. Банкны программын эсхүл үйл ажиллагааны алдаа /хүлээн авагчийн нэр, данс зөрүүтэй шилжсэн/-аас үүдэн харилцагчийн дансанд илүү мөнгө орсон тохиолдолд харилцагчийн данснаас уг мөнгөн хөрөнгийг үл маргах журмаар суутган авах зөвшөөрлийг харилцагч нь банканд үүгээр олгож байгаа болно.

## ГУРАВ. ТАЛУУДЫН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

### 3.1. Банк дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.1.1. Харилцагчийн гүйцэтгэсэн төлбөр тооцоог дансны боломжит үлдэгдэлд багтаан хүлээн авсан дарааллын дагуу гүйцэтгэх;

3.1.2. Харилцагчийн дансны дугаар, гүйлгээний талаарх мэдээлэл, дансны үлдэгдэл болон түүнтэй холбоотой бусад мэдээллийн нууцлалыг хадгалж, хуульд зааснаас бусад тохиолдолд бусад гаргаж өгөхгүй байх;

3.1.3. Харилцагчийн дансны үлдэгдэлд ХШЕН-д заасны дагуу хүү төлөх;

3.1.4. Шүүх, прокурор, цагдаа, татварын байгууллага болон бусад үл маргах журмаар төлөх төлбөрөөс бусад тохиолдолд харилцагчийн зөвшөөрөлгүйгээр данснаас зарлагын гүйлгээ хийхгүй байх;

3.1.5. Харилцагчид дансны хуулга, гүйлгээ, үлдэгдлийн талаарх мэдээллийг харилцагчийн хүсэлтийг үндэслэж, Банкны дотоод заавар, журмын дагуу гаргаж өгөх;

3.1.6. Банкны буруугаас хийгдсэн алдаатай гүйлгээг даруй залруулж, харилцагчийг хохиролгүй болгох;

3.1.7. БҮЕН, ХШЕН-д орох нэмэлт, өөрчлөлтүүдийг Банкны [www.tdbm.mn](http://www.tdbm.mn)

channels of the customer information centre, and register for products and services eligible for remote provision;

2.2.9. receive and process customer applications for obtaining loan services offered by the bank on a remote basis, and grant loans as requested by the customer should the relevant requirements be met.

2.3. The bank will verify customer ID as follows when providing products and services:

2.3.1. Where services are to be provided through branches and clearing and settlement centres of the bank, key information for verifying customer ID will be his or her photo, authorised signature and valid identity document.

2.3.2. The parties hereby consent and agree that in the event of remote banking services and products, the user name, password and PIN code used for products and services as specified in Clause 2.2 hereof, the customer's electronic mail and phone number registered with the bank, security questions and answers as well as other verification tools will be equally valid as the customer's authorised signature (*stamp or seal affixture*).

2.4. The parties agree that, where the customer applies for a loan or opening an account remotely, an agreement for such a product or service can be electronically confirmed using the form of verification specified in Clause 2.3.2 above, and such confirmation will be valid same as an agreement in writing.

2.5. 'General Banking Product and Service Terms' (*hereinafter referred to as 'GBPAST'*) means the general terms applicable to particular products and services, and rights, obligations and responsibilities of the parties whereas 'General Interest and Fee Terms' (*hereinafter referred to as 'GIAFT'*) means the interest and fees applicable to banking products and services respectively, both published for the public.

2.6. This agreement will take effect upon the customer confirming it with his or her signature, after reading and fully accepting the GBPAST and GIAFT in force at the time. The parties agree that going forward the customer will read amendments made to the GBPAST and GIAFT as published on the bank's website ([www.tdbm.mn](http://www.tdbm.mn)), and the bank will inform the customer via his or her electronic mail account registered with the bank.

2.7. The parties agree that if, after the bank informs the public on its website about any amendment to the GBPAST and GIAFT and the customer sends no objection, suggestion or request within the time frame specified herein, the parties will be deemed to have accepted the amendments.

2.8. By entering into this agreement with the bank, the customer allows it to view his or her details stored in the credit reference database as well as the electronic database.

2.9. Types of products and services to be received hereunder will be determined by the customer's present requests made when signing the agreement as well as future requests. Such requests will be annexed to this agreement.

## Three. General rights and obligations of the parties

### 3.1. The bank will have the following obligations:

3.1.1. To execute payments made by the customer within the available balance in the account according to the notified sequence;

3.1.2. To maintain confidentiality of the customer's account number, transaction details, account balance and other information relating thereto, and not disclose them to others unless otherwise stipulated in law;

3.1.3. To pay interest on the customer's account balance as provided for in the GIAFT;

3.1.4. Not to effect outgoing transactions from the customer's account without his or her permission except for payments ordered by courts, prosecutor's offices, police and taxation authorities as well as other payments

цахим хуудас болон харилцагчийн Банканд бүртгүүлсэн цахим шуудангийн хаягаар дамжуулан тухай бүр мэдээлэх;

3.1.8. Харилцагчийн харьяаллын улс нь Монгол Улсын Засгийн газартай давхар татварын гэрээ байгуулсан бол харилцагчийн харьяаллын улсаас олгосон татвар төлөгчийн сертификат (тухайн татварын жилд хамаарах), гадаад паспортыг үндэслэн хүүгийн орлогод ногдох татварыг давхар татварын гэрээнд заасан хэмжээгээр суутгаж татварын байгууллагад шилжүүлэх;

3.1.9. Харилцагч тухайн татварын жилд хамаарах татвар төлөгчийн сертификат, гадаад паспортыг банк хүүгийн орлого олгохоос ажлын 3 өдрийн өмнө Банканд өгөөгүй бол хүүгийн орлогод ногдох татварыг Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу суутгаж, татварын байгууллагад шилжүүлэх;

3.1.10. Хууль, гэрээгээр хүлээсэн бусад үүргийг биелүүлэх.

## 3.2. Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:

3.2.1. БҮЕН болон ХШЕН-д өөрийн санаачилгаар нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.2.2. Харилцагчийн данснаас зээл, хүүгийн төлбөр болон бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэлийг БҮЕН болон ХШЕН-д заасны дагуу үл маргах журмаар суутган авах;

3.2.3. Харилцагчийн шимтгэл төлөх дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд түүний бусад данснаас суутган авах;

3.2.4. Харилцагчийн бүх төрлийн дансны үлдэгдэл шимтгэл төлөхөд хүрэлцэхгүй буюу боломжгүй байгаа тохиолдолд Харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

3.2.5. Харилцагчийн хийсэн төлбөр тооцооны үнэн зөв эсэхэд эргэлзсэн, хүлээн зөвшөөрөхгүй байгаа, эсхүл алдаатай, илүү, дутуу болон давхар хийсэн аливаа маргаантай гүйлгээг (цаашид "Маргаантай гүйлгээ" гэх)-г шийдвэрлэхийн тулд маргаантай гүйлгээний дүнгээр дансанд түр хаалт тавих;

3.2.6. Маргаантай гүйлгээнд харилцагчийн буруутай үйлдэл нотлогдвол түүний данснаас хохирол, зардлыг үл маргах журмаар суутган авах;

3.2.7. Харилцагч Гэрээгээр хүлээсэн үүрэг болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн тохиолдолд Банк дараах үйлдлийг хийх эрхтэй. Үүнд:

3.2.7.а. Харилцагчийн гүйлгээ хийх эрхийг түдгэлзүүлж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг шаардах;

3.2.7.б. Харилцагчийн хийх гүйлгээ болон гүйлгээний дүнд тодорхой хязгаарлалтуудыг тогтоох;

3.2.7.в. Харилцагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг цуцлах;

3.2.7.г. Харилцагчийн буруугаас Банк болон аливаа этгээдэд хохирол учирсан бол Харилцагчийн Банкин дахь данснаас хохирлыг үл маргах журмаар суутган авах, дансны үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;

3.2.7.д. Дансны үлдэгдлээ санаатай болон санамсаргүй улайлган (өр болгох буюу дансны боломжит үлдэгдлээс хэтрүүлэх) ашигласан тохиолдолд төлж барагдуулахыг шаардах, бусад данснаас суутган авах, улайлтыг төлүүлэх талаар хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах.

3.2.8. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу харилцагчийн дансанд БҮЕН болон ХШЕН-ийн дагуу олгогдох хүүгийн орлого, түүнтэй адилтгах бусад орлогод ногдуулах албан татварыг суутгаж, холбогдох татварын байгууллагад шилжүүлэх;

3.2.9. Хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг харилцагчаас шаардах;

which must be made in an undisputed manner, i.e., without dispute;

3.1.5. To provide the customer with account statements and information with regard to transactions and balances based on customer request and in conformity with the bank's internal procedures and guidelines;

3.1.6. To immediately rectify erroneous transactions for which the bank is at fault, and indemnify the customer against any loss;

3.1.7. To inform of any amendment to the GBPAST and GIAFT in each instance by publishing the details on the bank's website ([www.tdbm.mn](http://www.tdbm.mn)) and/or notifying the customer via the electronic mail address registered with the bank;

3.1.8. If the customer's country of jurisdiction has a double taxation treaty with the government of Mongolia, to deduct taxes to be imposed on interest income at the rate stipulated in the treaty based on a taxpayer certificate issued by that jurisdiction (*covering the particular tax year*) and foreign passport, and transfer the amount to taxation authorities;

3.1.9. To deduct taxes to be imposed on interest income as stipulated in the relevant legislation of Mongolia and transfer the amount to taxation authorities if the customer fails to present his or her taxpayer certificate covering the particular tax year and foreign passport to the bank three (3) business days before the bank pays interest; and

3.1.10. To fulfil other obligations under law and the agreement.

## 3.2 The bank will have the following rights:

3.2.1 To make amendments to the GBPAST and GIAFT on its own initiative;

3.2.2 To deduct loan and interest payments and product and service fees from the customer's account without dispute as specified in the GBPAST and GIAFT;

3.2.3 If the customer's fee payment account contains insufficient funds, such fees will be charged to his or her other accounts, if any;

3.2.4 If the balance in all types of the customer's accounts is insufficient or unavailable to pay the fees due, the bank may decline to provide services to the customer;

3.2.5 Where legitimacy of a payment made by the customer is doubtful, a payment is not accepted or is erroneous or any transaction is disputed due to an excess, incomplete or double payment (*hereinafter referred to as 'disputed transaction'*), to place a temporary hold on the account until the dispute is resolved;

3.2.6 If the customer is found to be at fault in the disputed transaction, to deduct losses and costs from his or her account without further dispute;

3.2.7 If the customer breaches his or her contractual obligations and instructions and recommendations to use products and services, the bank is entitled to the following redress:

3.2.7.a. to suspend the customer's right to make transaction, and demand fulfilment of his or her contractual obligations and action to correct the breach;

3.2.7.b. to set restrictions or specific limits on the customer's transactions and transaction amounts;

3.2.7.c. if the customer fails to fulfil his or her contractual obligations, to terminate the agreement unilaterally and cancel his or her rights to products and services;

3.2.7.d. if the bank or any other person suffers a loss where the customer is at fault, to deduct any loss from the customer's accounts with the bank without dispute, and take other actions as stipulated in law if his or her account balance is insufficient to fully recompense for the loss; and

3.2.7.e. where the customer wilfully or unintentionally overdraws his or her account (*creating a debt or exceeding the account's available balance*), to demand payment, deduct from other accounts or take other actions, as

3.2.10. Хууль болон гэрээнд заасан бусад эрх.

### 3.3. Харилцагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.3.1. Банкны цахим хуудсанд нэвтэрч БҮЕН болон ХШЕН-д оруулсан нэмэлт, өөрчлөлттэй танилцах;

3.3.2. Карт, пин код, гар утас, нэвтрэх болон гүйлгээний нууц үг, бусад баталгаажуулалтын хэлбэрийг бусдад дамжуулсан, задруулсан, алдсан, нууцлалын төхөөрөмжийг гэсэн, алдсан, нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан аливаа эх үүсвэрээс гүйлгээ хийх оролдлого гаргасныг мэдсэн тохиолдолд Банканд нэн даруй мэдэгдэж үйлчилгээний эрхээ түр хаалгах, мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;

3.3.3. Дансанд заавал байлгах үлдэгдлийг тогтмол байршуулах;

3.3.4. Дансны үлдэгдлийг улайлган ашигласан тохиолдолд БҮЕН болон ХШЕН-д заасны дагуу шимтгэл, хүү, торгууль болон улайлгасан үндсэн дүнг яаралтай төлж барагдуулах;

3.3.5. Дансыг хамтран эзэмшигч, хамтран эзэмших эрх бүхий нэмэлт карт эзэмшигч болон нэмэлт утасны дугаарын бүртгэлээр дамжуулан Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж гүйлгээ хийхтэй холбоотой бий болох бүх төрлийн гүйлгээ, төлбөр тооцоо, төлбөл зохих үйлчилгээний хүү, шимтгэл, түүний үнэн бодит байдал, маргаан, эрсдэлийг бүрэн хариуцах;

3.3.6. Харилцагч дараах үйлдлүүдэд гарсан хохирлыг бүрэн хариуцна. Үүнд:

3.3.6.a. Харилцагчийн мэдээлэл өөрчлөгдөх бүрт Банкны тавьсан нөхцөлийн дагуу мэдэгдэж шинэчлүүлж байх, мэдэгдээгүйн улмаас банк болон харилцагчид учирсан аливаа хохирол;

3.3.6.b. Бүтээгдэхүүн, үйлчилгээний заавар, гарын авлагыг дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ зөрчсөнөөс үүсэх аливаа хохирол;

3.3.6.v. Дансны гүйлгээний хуулгаа тогтмол шалгаж ямар нэгэн маргаантай буюу хүлээн зөвшөөрөхгүй гүйлгээ хийгдсэн тохиолдолд гүйлгээ хийгдсэнээс хойш хүанлийн 30 хоногийн дотор Банканд мэдэгдэж шалгуулах, мэдэгдээгүйн улмаас бусад Банканд хандаж маргаан үүсгэх хугацаа өнгөрснөөс үүсэх хохирол;

3.3.6.g. Данс эсвэл карт эзэмшигч, картаар үйлчлэгч байгууллага болон карт гаргагч, эсвэл картаар үйлчлэгч банкны аль нэг талаас үл зөвшөөрөн маргаан үүсгэсэн карт болон дансны гүйлгээ шалгах явцад харилцагч нь Гэрээгээр хүлэсэн үүрэг болон бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан хохирол, зардал;

3.3.6.d. Пин код, нууц үг болон бусад баталгаажуулалтын мэдээллийг мартсан, бүрүү оруулсаны улмаас гүйлгээ хийж чадаагүй, гүйлгээ саатсанаас үүсэх аливаа хохирол;

3.3.6.e. Бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах явцад харилцагч нь гэрээнд заасан үүргийг биелүүлээгүйгээс Банканд болон гуравдагч этгээдэд санаатай болоод санамсаргүйгээр үүсгэсэн /үүсэх аливаа хохирол, зардал, асуудал/;

3.3.7. Харилцагч нь Монгол улс болон тухайн улсын Засгийн газар хооронд давхар татварын гэрээ байгуулсан гадаад улсын иргэн бол банк хүүгийн орлого олгохоос ажлын 3 хоногийн өмнө татвар төлөгчийн сертификат (тухайн татварын жилд хамаарах), гадаад паспортыг Банканд өгснөөр давхар татварын гэрээнд заасан хэмжээгээр татвар суутгуулах үүрэг үүснэ.

3.3.8. Хэрэв гэрээний 3.3.7-д зааснаар хүүгийн орлого авахаас өмнө татварын төлөгчийн сертификат, гадаад паспортыг Банканд өгөөгүй бол хүүгийн орлогыг Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу суутгуулах үүрэгтэй.

3.3.9. Харилцагч нь Ти Ди Би Онлайн үйлчилгээг ашиглан өөрийн сонгосон багцаас хамааран Банкны үйлчилгээ авах боломжтой ба тухайн сонгосон Ти Ди Би Онлайн багцын үйлчилгээний талаарх (ямар эрхтэй, ямар үйлчилгээ авах боломжтой гэх мэт) мэдээллийг Банкны [www.tdbm.mn](http://www.tdbm.mn) цахим хуудсын бүтээгдэхүүний танилцуулга хэсгээс

stipulated in law, for returning the account to credit.

3.2.8 In conformity with the legislation of Mongolia, to deduct taxes imposed on interest income to be paid to the customer's account under the GBPAST and GIAFT, and other income similar thereto, and transfer the amount to relevant taxation authorities;

3.2.9 To demand that the customer fulfil his or her obligations under law and the agreement; and

3.2.10 Other rights stipulated in law and the agreement.

### 3.3 The customer will have the following obligations:

3.3.1 To acquaint him or herself with amendments to the GBPAST and GIAFT as published on the bank's website;

3.3.2 If the customer conveyed, revealed or lost his or her card, card number, PIN code, mobile phone, access and transaction passwords and other verification details to others; mislaid or lost his or her vasco; or detected any attempt to make a transaction from any of his or her sources through unauthorised use of his or her access rights, the customer must notify the bank immediately and request that his or her service rights are temporarily suspended, failing which the customer will be fully liable for any resultant loss;

3.3.3 To regularly deposit the mandatory minimum amount in the account;

3.3.4 Where the account balance is overdrawn, to fully pay fees, interest and fines specified in the GBPAST and GIAFT as well as repay the overdrawn amount forthwith;

3.3.5 To take full responsibility for all types of transaction, payment, service fee and interest due and the accuracy thereof, as well as disputes and risks arising in connection with transactions made using banking products and services through registration of joint account holders, additional cardholders with joint account-holding rights and additional phone numbers;

3.3.6 The customer will be fully liable for any losses caused due to the following acts:

3.3.6.a. any loss caused to the bank and customer due to a failure to notify pursuant to the bank's terms every time the customer's details change;

3.3.6.b. any loss occurring due to a breach of his or her obligations to follow product and service instructions and manuals;

3.3.6.c. losses occurring due to expiry of time limits in dealings with other banks for opening a dispute because of the customer's failure to regularly check his or her account statements and notify the bank in respect of any disputed or unaccepted transaction so it can be checked, within thirty (30) calendar days of the transaction;

3.3.6.d. losses and costs occurring if the customer is found to be in breach of his or her contractual obligations, and product and service instructions and recommendations in the course of investigating a card or account transaction disputed by an account or card holder, an establishment that accepts card payments, a card issuer or a card service bank not accepting the transaction;

3.3.6.e. any loss arising from the customer forgetting the PIN code, password and other verification details or repeatedly entering wrong information resulting in a failure or delay in making a transaction; and

3.3.6.f. any loss, expense or issue which was, or is to be wilfully or unintentionally caused to the bank or a third person due to the customer's failure to fulfil his or her contractual obligations during use of products and services;

3.3.7. Where the customer is a citizen of a foreign country whose government has signed a double taxation treaty with the government of Mongolia, an obligation to deduct tax will be created in the amount stipulated in the treaty when the foreign citizen presents his or her taxpayer certificate (covering the taxation year) and foreign passport to the bank three (3)

шинэчлэгдсэн байдлаар авна.

3.3.10. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх.

#### **3.4. Харилцагч дараах эрх эдэлнэ. Үүнд:**

3.4.1. БҮЕН, ХШЕН-д орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрөхгүй бол нийтэд мэдээлсэн өдрөөс ажлын 30 хоногийн дотор Банканд хандан санал, хүсэлт гаргах;

3.4.2. Данс, карт болон банкны бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг банкны цахим сувгуудыг ашиглан захиран зарцуулах, тохиргоо, мэдээллийг бичгээр гаргасан хүсэлтийн дагуу эсхүл цахим сувгуудаар дамжуулан өөрчлөх, шинээр авах, эрхээ сэргээлгэх болон хаалгах;

3.4.3. Банканд бичгээр хүсэлт гарган, нотариатаар баталгаажуулсан гэрээслэл, өвлөх эрхийн гэрчилгээ болон итгэмжлэлээр өөрийн өв залгамжлагч болон данс ашиглах эрх бүхий этгээдийг тодорхойлох;

3.4.4. Хүсэлт гарган Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр авах, эрхээ сэргээлгэх болон хаалгах;

3.4.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах;

3.4.6. Банктай байгуулсан гэрээг хугацаанаас өмнө цуцлах, эсхүл сонгосон үйлчилгээнээс татгалзах;

3.4.7. Банкны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан зардал, хохирлыг банкаар төлүүлэх;

3.4.8. Хуульд заасан бусад эрх эдлэх.

#### **ДӨРӨВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

4.1. Төлбөр, тооцооны үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой Банк, Харилцагч болон Банкны гэрээт үйлчилгээ үзүүлэгч байгууллага эсхүл хүлээн авагчийн хооронд үүссэн маргаантай асуудлыг харилцагч, үйлчилгээний байгууллага эсхүл хүлээн авагчийн аль нэг талын хүсэлтээр 3 талын оролцоотойгоор хамтран зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ.

4.2. Банк, Монгол Улсын бусад банк болон гадаадын банкны сүлжээнд гарсан картын төлбөр тооцоо, МостМони, ТиДиБи Онлайнээр хийгдсэн төлбөр тооцоотой холбоотой маргааныг энэхүү гэрээ, Виза Интернэшнл, Мастеркарт Ворлдвайд болон ЮнионПэй Интернэшнл байгууллагуудын маргаантай гүйлгээ шалгаж шийдвэрлэх журам, Монголбанкны болон ХХБ-ны маргаан шийдвэрлэх заавар, журам, “ХХБ болон Гэрээт банктай байгуулсан хамтран ажиллах гэрээ” болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Гомдлыг шийдвэрлэх Ерөнхий хугацаа 180 хоног байх бөгөөд тухайн маргааны төрлөөс шалтгаалан холбогдох журамд заасны дагуу тодорхойлогдоно.

4.3. Хэрэв Гэрээний 4.1-4.2-д заасан журмаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын хуулийн дагуу, Монгол Улсын Шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.

#### **ТАВ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ, ДАНС ХААХ**

5.1. Дараах тохиолдолд энэхүү гэрээг цуцалж, дуусгавар болгоно. Үүнд:

5.1.1. Харилцагчийн хүсэлтийг үндэслэж гэрээг цуцалж, дуусгавар болгоно. Гэрээг цуцалсанаар харилцагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээ эзэмших эрхийг цуцалж, данс болон бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг хаана.

5.1.2. Хэрвээ харилцагч нь данс болон бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдох аливаа өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй бол тухайн төлбөрийг барагдуулж дуустал дансанд битүүмж тавьж, барагдуулж дууссан өдрөөс гэрээг цуцалж, гэрээний хугацааг дуусгавар болсонд тооцож, харилцагчийн дансыг хаана.

5.1.3. Харилцагч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд Банк гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх эрхийг дуусгавар болгоно.

5.1.4. Харилцагч өөрийн дансыг төлбөр тооцооны бус зориулалтаар удаа дараа (2 болон түүнээс дээш) ашигласан (бусдын нэр дээр банкны баталгаа, тодорхойлолт гаргах үйлчилгээ эрхлэх, дансыг ашиглан бусдад хохирол учруулж болзошгүй буюу залилан луйврын шинжтэй үйлдэл

business days before the bank pays interest;

3.3.8. If the customer fails to submit a taxpayer certificate and foreign passport to the bank before receiving interest income as stipulated in Clause 3.3.7 above, he or she is under a duty with regard to deduction of interest income in accordance with the legislation of Mongolia;

3.3.9. To fully discharge his or her contractual obligations.

#### **3.4 The customer will have the following rights:**

3.4.1 If the customer does not accept amendments to the GBPAST and GIAFT, to make comments or requests to the bank within ten (30) business days of the amendments being made public;

3.4.2 To use funds in his or her accounts, cards and other banking products and services through the bank's electronic channels, change or receive details of new settings and information upon making a written request or through electronic channels, and have his or her rights restored or terminated;

3.4.3 Upon making a written request to the bank, to designate his or her heir and/or person authorised to use his or her accounts by having a will certified by a notary, a certificate of inheritance or a power of attorney;

3.4.4 Upon making a request, to newly receive banking products and services, and have his or her rights restored or terminated;

3.4.5 To demand that the bank fulfil its contractual obligations;

3.4.6 To cancel the agreement with the bank earlier, or decline chosen services;

3.4.7 To obtain compensation from the bank for expenses and losses caused due to its actions; and

3.4.8 Other rights stipulated in law.

#### **Four. Dispute resolution**

4.1 Any matter in dispute between the bank, the customer and an entity that provides or receives services under a contract with the bank with regard to the provision of payment, clearing and settlement services will be resolved through tripartite consultation at the request of either of the disputing parties.

4.2 A dispute occurring in a network of the bank, any other bank of Mongolia or a foreign bank relating to a payment made by a card, MostMoney or TDB Online will be resolved under this agreement, the procedures applied by Visa International, MasterCard Worldwide and UnionPay International for the investigation and resolution of disputed transactions, the dispute resolution guidelines and procedures of Mongolbank and TDB, Agreement for cooperating with TDB and the contracted bank as well as other applicable laws. The general time frame for deciding on a complaint will be 180 days, and will be determined as specified in relevant procedures depending on the type of dispute.

4.3 In the event of a failure to resolve a dispute as provided for in Clauses 4.1-4.2 above, it will be decided by a court of law in Mongolia in accordance with Mongolian law.

#### **Five. Cancellation or termination of the agreement, and account closure**

5.1. This agreement will be terminated in any of the following events:

5.1.1. The agreement can be cancelled or terminated based on customer request. With the agreement's cancellation, the customer's rights to products and services will be terminated, and accounts, other products and services withdrawn.

5.1.2. If the customer fails to fully pay any debt associated with his or her accounts, products and services, his or her accounts will be placed on hold until the payment is made in full and the agreement will be cancelled on the date of full payment, being deemed as expired and the customer's account

гарах нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагаа) болон Банканд, гуравдагч этгээдэд хохирол учруулах үйлдлийг удаа дараа гаргасан тохиолдолд Банк гэрээг дангаар цуцалж, данс болон бүтээгдэхүүн, үйлчилгээний эрхийг хаах эрхтэй.

5.1.5. Хуульд заасан бусад үндэслэлээр.

#### **ЗУРГАА. ХАРИУЦЛАГА**

6.1. Харилцагч төлбөр тооцооны баримтыг хуурамчаар үйлдэх, залилан мэхлэх болон гэрээгээр хүлээсэн бусад үүргийг зөрчих замаар Банканд хохирол учруулсан бол хохирлыг дансан дахь мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар төлнө.

6.2. Харилцагчийн дансны үлдэгдэл хүрэлцээгүй, төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэр дутуу, буруу болон хүлээн авагч банкны үйлчилгээний доголдол зэрэг шалтгааны улмаас харилцагчийн төлбөр саатсан бол үүсэх үр дагаврыг банк хүлээхгүй.

6.3. Талуудын аль нэг нь гэрээг зөрчсөнөөс нөгөө талдаа учирсан бодит хохирол, зардлыг гэрээг зөрчсөн тал бүрэн хариуцна.

6.4. Энэхүү гэрээ цуцлагдсан, дуусгавар болсон тохиолдолд энэ гэрээг хүчин төгөлдөр байх үед үүссэн төлбөр тооцооны эрх, үүрэг нь бүрэн биелэгдэж дуусах хүртэл хугацаанд энэ гэрээний зохицуулалт нь талуудын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

6.5. Харилцагч нь өөрийн дансны дугаар, карт болон картын дугаар, хүчинтэй хугацаа, CVV код, пин код, интернэт пин код болон соронзон түүзны нууцлалын мэдээлэл, бусад бүтээгдэхүүн, үйлчилгээнд ашиглах харилцагчийн нэвтрэх нэр, нууц үг, гүйлгээний нууц үг, нэг удаагийн нууц дугаар, ТАН код болон бусад нууцлалын мэдээллийг гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр дамжуулахгүй, алдахгүй байх, хэрэв дамжуулсан болон алдсаны улмаас хохирол учирвал түүнийг бүрэн хариуцна.

6.6. Бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглах явцад харилцагч нь энэхүү гэрээнд заасан үүргийг биелүүлээгүйгээс Банканд болон гуравдагч этгээдэд санаатай болоод санамсаргүйгээр үүсгэсэн /үүсэх аливаа хохирол, зардал, асуудлыг харилцагч бүрэн хариуцна.

6.7. Харилцагч Америкийн Нэгдсэн Улсын харьяат иргэн бол W-9 маягтад заасан өөрийн болон дансны мэдээлэл, TIN эсхүл SSN эсхүл EIN дугаарыг АНУ-ын Internal Revenue Service (IRS)-д мэдээлэх зорилгоор Банканд мэдэгдэх, мэдэгдээгүйн улмаас үүсэх хариуцлагыг харилцагч хариуцна.

#### **ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ**

7.1. Энэхүү гэрээг бичгээр байгуулах тохиолдолд хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгална. Харин энэ гэрээг цахим хэлбэрээр (Ти Ди Би Онлайн) байгуулах тохиолдолд Банканд Харилцагчийн зөвшөөрсөн үйлдэл (гэрээг зөвшөөрсөн тухай мэдээлэл) хадгалагдана. Дээрх хоёр тохиолдол хууль зүйн хувьд адил хүчинтэй.

7.2. Харилцагч Гэрээний 2.2-д заасан бүтээгдэхүүн, үйлчилгээг авахдаа Банкнаас үзүүлж буй цахим сувгийг ашигласан нь Харилцагч Банканд өөрийн биеэр ирж, төлбөр тооцооны баримтаар гүйлгээ хийлгэж, үйлчлүүлсэнтэй адил тооцогдож, хүчин төгөлдөр байна.

7.3. Харилцагч төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхэд тухайн цаг хугацаанд Банкнаас зарласан арилжааны ханш, олон улсын сүлжээг ашиглах бол тухайн банкны хүү, шимтгэл, ханшийг хүлээн зөвшөөрч, гүйлгээ хийхийг Талууд үүгээр харилцан тохиролцов.

7.4. Гэрээний дагуу эзэмшиж байгаа данс, данс дахь дундын өмчийн хөрөнгийг харилцагч болон хамтран эзэмшигч хэн нэгнээсээ тухай бүрт зөвшөөрөл авахгүйгээр захиран зарцуулахыг үүгээр зөвшөөрч байна. Цаашид данснаас гүйлгээ хийх бүрд данс дахь мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах зөвшөөрөл бие биедээ олгохгүй бөгөөд Иргэний хуулийн 108 дугаар зүйлийн 108.4 дэх хэсэгт заасан зөвшөөрөл олгогдсоноор тооцооор талууд харилцан тохиролцов. (Энэхүү нөхцөл нь дансыг хамтран эзэмших тохиолдолд хамаарна, мөн харилцагч дансанд хамтран эзэмшигч бүртгүүлэхдээ данснаас хөрөнгө захиран зарцуулах хэмжээг зааж хязгаарласан тохиолдолд хамаарахгүй болно)

7.5. Харилцагч энэхүү гэрээний 2.2-д заасан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хэсэгчлэн болон дахин авсан тохиолдолд тухайн авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд энэхүү гэрээний нөхцөл мөрдөгдөхөөр харилцан тохиролцов.

closed.

5.1.3. If the customer commits a serious breach of his or her contractual obligations, the bank will unilaterally cancel the agreement and terminate his or her rights to use products and services.

5.1.4. If the customer repeatedly (*twice or more*) uses his or her account for non-payment purposes (*engaging in service to secure a bank guarantee or reference letter in the name of others and for activities which could cause losses to others using the account or acts of a fraudulent nature*) and causes any loss to the bank or third persons repetitively, the bank is entitled to unilaterally cancel the agreement and close the account, and withdraw his or her rights to products and services.

5.1.5 On other grounds stipulated in law.

#### **Six. Responsibilities**

6.1. If the customer causes any loss to the bank by fraudulently producing payment documents, committing a fraud and/or breaching his or her other contractual obligations, such losses will be recompensed from funds in his or her accounts without dispute.

6.2. If the customer's payment is delayed due to insufficiency of the customer's account balance, incomplete or invalid payment documents, or a defect in the receiving bank's services, the bank will not be liable for consequences thereof.

6.3. The party at fault will be liable for any actual losses or expenses caused to the other party due to the former's breach of the agreement.

6.4. Where this agreement is cancelled, terminated or expired, the provisions hereof will remain valid and binding on the parties until the payment and settlement rights and obligations which were created when the agreement was effective are fully discharged.

6.5. The customer must not convey or reveal his or her account number, card, card number, the term of validity, CVV code, PIN code, the Internet purchase code, the data stored on the magnetic stripe and user name, password, transaction password, one-time password, transaction authentication number, and other confidential information for accessing other products and services to third persons in any form. The customer will be fully liable if any loss is thus incurred.

6.6. The customer will be fully liable for any loss, expenses and/or issues which were, or might be wilfully or unintentionally caused to the bank and third persons due to a failure to fulfil his or her contractual obligations while using products and services.

6.7. If the customer is a citizen of the United States of America, he or she will take responsibility arising due to a failure to notify the bank of his or her personal and account details, TIN, SSN or EIN specified in Form W-9 for the purpose of informing the Internal Revenue Service (*IRS*) of the USA.

#### **Seven. Miscellaneous provisions**

7.1. Where this agreement is to be made in writing, it will be executed in two (2) countercopies, with each party keeping a copy. If it is made electronically (*TDB Online*), the customer's permission and acceptance (*information about consenting to the agreement*) will be kept with the bank. Agreements made using these two methods will have equal legal effect.

7.2. The customer's use of the bank's electronic channels when receiving products and services specified in Clause 2.2 hereof will be as valid as him or her arriving and being served at the bank in person, ordering transactions using payment slips.

7.3. The parties hereby agreed that if the customer is to use the exchange rate declared by the bank at the time and an international network when executing payments in a foreign currency, such bank's interest,

fees and exchange rate will be accepted and transactions made accordingly.

- 7.4. The customer and his or her joint account holder(s) hereby consent that they may use the account held under the agreement and jointly owned funds in the account without having to obtain permission from one another in each instance. The parties agree that for each future transaction from the account, permission to use funds in the account will not be granted to each other, but permission specified in Clause 108.4, Article 108 of the Civil Code will be deemed as granted (*This term applies to joint holding of the account; it will not apply where the customer sets caps on the amount to be disposed of from the account, when registering a joint holder for the account*).
- 7.5. The parties agree that when the customer receives banking products and services specified in Clause 2.2 hereof partly or again, the terms hereof will apply to such products and services.

**SIGNATURE VERIFICATION\***

Customer's full name	Specimen signature

**\*When the customer signs payment documents, he or she will affix the same signature as verified in this form.**

**The customer has read the terms of this agreement in full and affixed his or her authorised signature confirming acceptance of the terms, GBPAST and GIAFT.<sup>1</sup>**

**For the Bank:**

**For the Customer:**

/Signature/.....

/Signature/.....

Sales and Information Officer:

Name:

Senior Operations Officer:

E-mail:

.....

Phone:

---

<sup>1</sup> If the customer is under 18 years of age, his or her parent, custodial parent or guardian accepts and affixes verified signature.